

“МАХИМПЭКС” ХК-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Илтгэгч: Ж.Чинзориг “Махимпэкс” ХК-ийн
ТУЗ-ийн дарга

2017 оны 04 дүгээр сарын 26

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, урилгаар оролцож байгаа эрхэм хүндэт зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг Махимпэкс ХК-ийн нийт ажилтан, ажилчдын өмнөөс болон хувиасаа хүргэж байгааг хүлээн авна уу.

Махимпэкс ХК-ийн ТУЗ-өөс 2017 онд хийсэн ажлын тайлангаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж та бүхний гаргасан үнэтэй санал санаачлага, шүүмжлэлийг 2018 оныхоо ажилд тусган хэрэгжүүлэх болно.

Өнгөрсөн онд тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаа.

УИХ-аар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр-т хүнсний салбарт дараахь зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.
- Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих;
- Стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх;
- Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;
- Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;
- Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх;

- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.
- Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ.
- Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ.
- Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.
- Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.

Нэг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор батлагдсан “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн яамнаас зарласан тендерт шалгарч ХХБ-аас 3,8 тэрбум төгрөгийн зээл авч:

- Хонины мах 390,1 тонн
- Үхрийн мах 146,5 тонн
- Ямааны мах 438,9 тонн

Бүгд 975,6 тонн мах бэлтгэж 4,5,6 дугаар сард махыг зарж 4,1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. **Авсан 3,8 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хамт ХХБ-тай байгуулсан гэрээний дагуу хугацаандаа төлж барагдуулан дараагийн зээл авах боломж бүрдүүлсэн.**

Голомт банктэй эвлэрлийн гэрээ байгуулж үлдэгдэл зээлийн асуудлыг шийдсэнээс гадна банкны зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг чөлөөлүүлж чадлаа.

2016 онд эхэлсэн “Малчдыг дэмжих” хөтөлбөрийг үргэлжлүүлэн тайлант оны 9 дүгээр сараас эхлэн “ХКҮ” ХХК-ийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд 1250 толгой үхэр төхөөрч 200,0 тонн мах бэлтгэсэн байна. **Энэ нь тайлант онд бэлтгэсэн махны хамгийн хямд үнэ болж байна.** “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн ямаа бэлтгэх төсөл боловсруулан энэ онд 149,7 тонн ямааны мах бэлтгэж ХКҮ ХХК-ийн үйлдвэрийн хэрэгцээнд өгсөн байна.

Мөн ИБНИУ-ын Голден такал компанитай хонины мах экспортлох гэрээ байгуулж 431,2 тонн төлөгний мах гэрээний дагуу нийлүүлж 2,946,825,846 төгрөгийн борлуулалтын орлого оруулсан байна.

БНХАУ-ын атестатчилал гэрээтэй холбогдуулан үйлдвэрийг бэлдэн тус улсын чанарын хяналт хорио цээрийн газрын шаардлагын дагуу бүрдүүлэх материалыг “Махимпэкс” ХК-иас баг гарган гүйцэтгүүлж атестатчилалд оролцож шалгуулсан болно. Уг шалгалтын дагуу “Махимпэкс” ХК-аас

БНХАУ-д адууны мах экспортлох, дотоодод мах чанаж БНХАУ-д экспортлох үйлдвэрүүдэд үйлдвэрийн аргаар төхөөрсөн махыг нийлүүлэх эрх авсан болно. Уг ажлын хүрээнд цаашид үйлдвэрлэлээс хамаарахгүй ашиг олох боломж бүрдэж байна. (2018 оны Эдийн засгийн тооцоонд тодорхой тусгана) Энэ ажлын үр дүнд 2017 онд зөвхөн 12 дугаар сард **500,0 тонн адууны мах гаргасан** байна.

Компанийн хашаанд байгаа үйлдвэрүүдтэй хийсэн гэрээг өөрчлөн шинэчилж чадсанаар компанийн хувьд гэрээг ашигтай болгож чадсан.

Номин сүлжээ дэлгүүрийн шинээр нээгдсэн Наадам центр салбарт өөрийн үйлдвэрийн махны дэлгүүрийг нээн ажиллуулж байна. Энэхүү салбар дэлгүүрийн дотоод тохижилт болон тоног төхөөрөмжийн зардалд нийт 15,6 сая төгрөг зарцуулсан байна.

“Махимпэкс” ХК-ын цахилгааны ерөнхий шугамын хэмжүүр шаардлага хангахгүй байсныг шинэчлэн цагийн тариф тоолууртай болгон өөрсдөө өдөр болгон хянах боломжтой болголоо. Ингэснээр “Махимпэкс” ХК-ын цахилгааны төлбөрийг хэмнэж чадсан.

Эрчим хүчний удирдах газартай хамтран эрчим хүч хэмнэх бодлого баримтлан үүрэг хүлээсэн хэрэглэгчээр шалгарч компанийн хэмжээнд эрчим хүч хэмнэж болох тооцоог гарган гадны байгууллагаар эрчим хүч хэмнэх аудит хийлгэн хөрөнгө босгох бололцоог бүрдүүлээд байна. Уг тооцоогоор компанийн хэмжээнд жилд **179,0 сая төгрөгийн хэмнэлт** гаргах боломжтой юм. Мөн эрчим хүч хэмнэлтийн менежер томилж сургалтад суулган дадлагажуулаад байна.



Үйлдвэрийн хойд талын төв замын засварын ажил дуусч хашаа руу орц, гарц оруулан, ар талын модон хашааг бетон зуурмаг хийцтэй хашааг 180,0 сая төгрөгөөр хийлгэн, машин ордог 2 хаалга хийж, орчны тохижилтыг сайжруулан 110 ширхэг мод, болон гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэсэн.

Компанийн хэмжээнд байгаа барилга байшинг ашиглах зорилгоор хуучин ажилчны цайны газрын барилгыг дулааны аргаар мах боловсруулах цех болгон түрээслэсэн юм. Энэ ажлын дүнд:

- Ашиглалтгүй барилгыг ашиглалтанд оруулсан
- Барилга, цахилгаан, сантехникийн тоног төхөөрөмжийн засварын зардалгүйгээр дээврээс бусад зүйлийг засварлуулж чадсан.

Компанийн нийт ажилчдыг группын амралтанд 50 хувийн хөнгөлттэй үнээр амраасан. Үйлдвэрийн мэргэжлийн онцлогоос шалтгаалж Хужирт рашаан сувилалд 48 хүн амрааснаас тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан өндөр настан 6 хүн амарчээ. Мэргэжилтнүүдийн залуу халаа бэлтгэх зорилгоор хөргөлтийн инженер-2, дулааны инженер-1, цахилгааны инженер-1-ийг тус тус авч дадлагажуулан ажиллуулж байна. Мах боловсруулах үйлдвэрийн технологийн ажилтнуудыг 6 сар тутамд машин танхимын ажилтнуудыг ээлжит мэргэжлээс шалтгаалан үндэсний төвийн үзлэгт хамруулсан.

Дээрх байдлуудаас дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Малчдыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн явуулах боломжтой юм. Тэгэхдээ 8,9,10 дугаар саруудад хонь, үхэр, адууг амьдаар нь авч бэлтгэх нь хамгийн оновчтой арга байлаа.
2. Ямааны махыг 10, 11,12 дугаар сард тусад төсөл хэрэгжүүлэн гүйцэтгэвэл болох юм гэж үзэж байна.
3. -40 хэмийн хөлдөөлтийн хүчин чадлыг зайлшгүй нэмэх шаардлагатай байна.
4. Зарим тоног төхөөрөмжийг зайлшгүй захиалан авах шаардлагатай байна. Үүнд:
 - Бүслүүрийн машин
 - Вакум машин
 - Блоклон хөлдөөгчийн сэлбэг
 - Гулууз хөрөөний сэлбэг
 - Аммиакны насос-2 ширхэг
 - Усны насос
 - Халаалтын насос
5. Цаашид хөргөх үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх.
6. Компанийн хэмжээнд экспортын үйл ажиллагаа явуулахад НАССР төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай болж байна. Иймд мэргэжлийн зөвлөх байгууллагаар НАССР төлөвлөгөө хийлгэж баталгаажуулан гүйцэтгэл хийлгүүлэх
7. Мэргэжилтэй ажилтан, ажилтнаар бэхжүүлэх дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг ажлууд зайлшгүй хийх шаардлагатай юм.

Хоёр. Санхүүгийн үйл ажиллагааны тайлан

Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооноос 2017 оны санхүүгийн тайлангийн эдийн засгийн үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааг 2016 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд:

Балансынүзүүлэлт	2016 он	2017 он	Шинжилгээ	
			төгрөгөөр	хувиар
Эргэлтийнхөрөнгө				
Мөнгөнхөрөнгө	33,894,026.79	104,268,617.51	70,374,590.72	208%
Богинохугацаатавлага	7,060,163,108.35	6,774,131,258.87	-286,031,849.48	-4%
Татвар, НДШ-ийнавлага	157,283,405.85	86,642,583.01	-70,640,822.84	-45%
Барааматериалыннөөц	653,666,254.46	1,000,502,592.78	346,836,338.32	53%
Урьдчилжтөлсөнзардалтооцоо	0.00	8,996,700.00	8,996,700.00	
Эргэлтийнбусхөрөнгө				
Үндсэнхөрөнгө	1,854,475,070.07	1,874,351,673.99	19,876,603.92	1%
Биетбусхөрөнгө	4,810,351.40	4,810,351.40		
Богинохугацаатөртөлбөр				
Дансныөглөг	5,633,772,581.08	5,481,432,157.04	-152,340,424.04	-3%
Цалингийнөглөг	25,853,036.00	30,699,858.00	4,846,822.00	19%
Татварынөр	84,797,970.80	22,712,591.82	-62,085,378.98	-73%
НДШ-ийнөглөг	-2,772,284.10	-4,090,421.10	-1,318,137.00	48%

Санхүүгийн үйл ажиллагааны нэг гол үзүүлэлт бол эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээ түүний тогтвортой ажиллагаа байдаг. Үүнээс түргэн эргэх мөнгөн хөрөнгө 104,2 сая төгрөг, боломжит эргэх хөрөнгө 6860,7 сая төгрөг байгаагийн 7.8% буюу 527,2 сая төг нь найдваргүй авлага эзэлж байна. Түргэн болоод боломжит эргэлтийн хөрөнгө нь компанийн жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд хэвийн явуулахад хүрэлцэхүйц байна. Иймээс компани 2018 онд борлуулалт үр дүнгээ нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгийн суурийг чадавхижуулах тал дээр анхааран ажиллах шаардлагатайг харуулж байна. Дансны авлага 286.0 сая төг-өөр буурсан нь компаниас авлага барагдуулах тал дээр тодорхой үе шаттай үйл ажиллагаа явуулсны үр дүн юм.

Эргэлтийн хөрөнгийн нийт дүнд голлох байр суурийг бараа материал эзэлж байгаа нь тус компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл онцлогтой холбоотой бөгөөд хувийн жин нь 3,5%-иар өссөн нь үүнийг гэрчилнэ.

Дансны өглөгийг урьд оноос 152.3 сая төг-өөр бууруулан өглөг авлагын харьцаа 1,1 байгаа нь хэвийн үзүүлэлттэй байна. Мөн дээр нь бараа, бэлэн бүтээгдэхүүний хангалттай эх үүсвэртэй байгаа нь эерэг үзүүлэлт юм. Хөрөнгийн хөрвөх чадварын харьцааг дээшлүүлэхийн тулд компани дээр дурдсанчлан зардлаа бууруулж ашгийн түвшинг нэмэгдүүлэх нь зах зээлийн тогтворгүй байдалд бага өртөх, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой болох юм.

Компанийн хувьд өөрийн үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулж байгаа мөн зах зээлд өөрийн гэсэн байр сууриа нэгэнт олсон, бусад ижил төрлийн мал, мах бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг компаниудын дунд хүчтэй өрсөлдөгчдийн нэг гэдэг утгаараа цаашид илүү их амжилттай ажиллаж үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулж чадах нь харагдаж байна.

Орлого, үр дүнгийн тайланд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн болон татварын зардлууд нь ашгийн зохих шатлалд хэрхэн нөлөөлж буйг дүгнэвэл:

Үзүүлэлт	2016 он	2017 он	Хэвтээшинжилгээ	
			төгрөгөөр	хувиар
Борлуулалтынорлого (цэвэр)	7,511,789,751.6 0	10,325,984,391.8 4	2,814,194,640.24	37.5%
Борлуулалтынөртөг	7,640,015,570.0 8	9,826,706,192.09	2,186,690,622.01	28.6%
Нийташиг (алдагдал)	-128,225,818.48	499,278,199.75	627,504,018.23	-489.4%
Үйлажиллагааныбусадорлого	3,822,448,741.4 3	2,244,006,013.76	1,578,442,727.67	-41.3%
Үйлажиллагаанызардлындүн	2,389,171,590.8 4	2,346,743,315.74	-42,428,275.10	-1.8%
Борлуулалт, маркетингийнзардал	7,600,321.74	10,655,103.06	3,054,781.32	40.2%
Ерөнхийбаудирдлагынзардал	625,578,386.12	435,755,092.40	-189,823,293.72	-30.3%
Бусадзардал	1,755,992,882.9 8	1,900,697,738.09	144,704,855.11	8.2%
Гадаадвалютынханшийнзөрүүнийо лз (гарз)	10,080,384.32	-364,617.81	-10,445,002.13	-103.6%
Татвартөлөхийнөмнөхашиг (алдагдал)	1,315,131,716.4 3	395,811,662.15	-919,320,054.28	-69.9%
Орлогынтатварынзардал	133,071,932.00	41,059,187.49	-92,012,744.51	-69.1%
Татварындараахашиг (алдагдал)	1,182,059,784.4 3	354,752,474.66	-827,307,309.77	-70.0%